

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт

Хагас жилийн үйл ажиллагааны тайлагнал /маягт 2/			
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.			
Тайлагнах хугацаа	2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдөр		
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХК УБГД:9022001010, ҮЦКод:510 Утасны дугаар : 11-313747		
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж ХК		
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Үнэт цаасны зах зээлд үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагаа болон өөрийгөө зохицуулах байгууллага		
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	350,463,539 ширхэг		
Хагас жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Д.Нямдорж /Бүртгэлийн албаны ахлах мэргэжилтэн/ Х.Эрдэнэбүрэн /Захиргаа санхүүгийн газрын дарга/		
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/		
Санхүүгийн байдлын үзүүлэлт	Үзүүлэлт	1/1/2025	06/30/2025
	ХӨРӨНГӨ		
	Эргэлтийн хөрөнгө	819,315,100,436.48	830,464,098,988.98
	Эргэлтийн бус хөрөнгө	24,372,688,896.84	24,097,405,663.23
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	843,687,789,333.32	854,561,504,652.21
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
	Богино хугацаат өр төлбөр	768,214,133,718.83	783,397,788,434.31
	Урт хугацаат өр төлбөр	1,564,242,730.26	940,353,374.69
	Эздийн өмчийн дүн	73,909,412,884.23	70,223,362,843.21
	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	843,687,789,333.32	854,561,504,652.21
Орлогын тайлан	Үзүүлэлт	1/1/2025	06/30/2025
	Борлуулалтын орлого(цэвэр)	13,521,664,119.64	3,212,172,739.09
	Борлуулалтын өртөг	5,166,647,083.45	2,505,236,866.35
	Нийт ашиг(алдагдал)	8,355,017,036.19	706,935,872.74
	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	37,975,864,704.43	13,510,090,258.43

	Орлогын татварын зардал	3,799,182,441.16	1,469,799,734.82
	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)	34,176,682,263.27	12,040,290,523.62
	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Орлогын нийт дүн	34,176,682,263.27	12,040,290,523.62
Өмчийн өөрчлөлтийн тайлан	Үзүүлэлт	1/1/2025	30/06/2025
	Өмч	35,046,353,900.00	35,046,353,900.00
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	20,005,435,662.81	19,987,924,558.50
	Эздийн өмчийн бусад хэсэг	446,321,902.02	2,217,282,386.53
	Хуримтлагдсан ашиг	18,411,301,419.40	12,971,801,998.18
	Нийт эздийн өмчийн дүн	73,909,412,884.23	70,223,362,843.20
Мөнгөн гүйлгээний тайлан	Үзүүлэлт	1/1/2025	30/06/2025
	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(83,765,571,299.69)	(9,598,135,900.70)
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,161,264,932.69)	(1,036,510,699.00)
	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		(16,186,706,237.35)
	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(86,465,260,283.98)	10,362,594,188.48
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	902,582,814,516.91	816,117,554,232.93
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	816,117,554,232.93	826,480,148,421.41
2.	Хагас жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, баталгаажуулсан ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт		
ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны ээлжит хурлаар хэлэлцүүлэх болно.			
3.	Тайлант хугацаанд үнэт цаас гаргагчийн санхүүгийн үйл ажиллагаанд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлс, санхүүгийн тайлангийн шинэжилгээ, орлого, зарлага, ашгийн үзүүлэлтүүдийг тооцоож дүгнэсэн удирдлагын тайлан, дүгнэлт		
3.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Нийт ашгийн хувь Цэвэр ашгийн хувь Өөрийн хөрөнгийн өгөөж Нийт хөрөнгийн өгөөж	22.01% 67.21% 17.15% 1.41%
3.2.	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Эргэлтийн харьцаа Түргэн хөрвөх чадварын харьцаа Өр болон өөрийн хөрөнгийн харьцаа	1.06 1.06 12.17
	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл	• Үнэт цаасны арилжаа: Дотоодын үнэт цаасны зах зээлийн чиг хандлагыг тодорхойлогч гол үзүүлэлт болох ТОП-20 индекс	

3.3.	ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	2025 оны эхний хагас жилд 54,018.32 нэгжид хүрч өссөн бол доод үзүүлэлт нь 46,334.87 нэгж, дундаж үзүүлэлт нь 50,271.15 нэгж байсан бол энэ оны 6 дугаар сарын 30-ны байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4,860.99 нэгж буюу 10.95 хувиар өсөж, 49,246.17 нэгж болсон байна. Зах зээлийн үнэлгээ 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 12.13 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 849.78 тэрбум төгрөг буюу 7.53 хувиар өссөн байна. Харин үнэт цаасны арилжааны хувьд, 2025 оны эхний хагас жилд нийт 124 удаагийн нийт 324.3 тэрбум төгрөгийн арилжаа зохион байгуулсан байна. Тодруулбал, хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 143 хувьцаат компанийн 607.65 сая ширхэг хувьцааг 110.88 тэрбум төгрөгөөр, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 745.36 мянган ширхэг үнэт цаасыг 64.37 тэрбум төгрөгөөр, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжаагаар 5.22 сая ширхэг нэгж эрхийг 4.24 тэрбум төгрөгөөр, компанийн бондын анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаагаар 556.45 сая ширхэг бондыг 86.74 тэрбум төгрөгөөр, Засгийн газрын дотоодын үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаагаар 600.0 мянган ширхэг дотоодын үнэт цаасыг 58.06 тэрбум төгрөгөөр тус тус арилжааллаа. Тайлант хугацаанд өдөрт дунджаар 4.95 сая ширхэг үнэт цаасыг 2.61 тэрбум төгрөгөөр арилжсан байна. Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа: 2025 оны эхний хагас жилд нийт 494 удаагийн уул уурхайн бүтээгдэхүүний цахим дуудлага арилжаа зохион байгуулагдсан байна. Тайлант хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-иар дамжуулан “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой” ХК, “Энержи Ресурс” ХХК, “Хангад Эксплорэйшн” ХХК, “Андын Илч” ХХК нь 2.34 сая тонн нүүрсийг 610.19 тэрбум төгрөгөөр, “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ, “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК нь нийт 2.96 сая тонн төмрийн хүдэр болон баяжмалыг 630.51 тэрбум төгрөгөөр, “Очир Мандал Хайрхан” ХХК, “Эрдэнэс Критикал Минералс” ТӨҮГ нь нийт 18,265 тонн хайлуур эсонины хүдэр баяжмалыг 17.35 тэрбум төгрөгөөр, “Эрдэнэт Үйлдвэр” ТӨҮГ 20,000 тонн зэсийн баяжмалыг 139.53 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалсан бөгөөд нийт 5.33 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 1,397.59 тэрбум төгрөгөөр арилжаалсан байна.
------	--	--

		Шинэ бүтээгдэхүүн: Тайлант хугацаанд "Омни ассет хоёр ТЗК" ХХК-ийн 14.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 140,000 ширхэг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, "Бизнес-Инвест девелопмент ББСБ" ХХК-ийн 10.0 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй 100,000 ширхэг бонд болон Засгийн газрын дотоодын үнэт цаасны 58.06 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 600,000 ширхэг бондын анхдагч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгуулав. 2025 оны 6 дугаар сарын 30-ны байдлаар Монголын хөрөнгийн бирж дээр 164 ХК-ийн хувьцаа, Засгийн газрын 12 бонд, Нийслэлийн 3 бонд, 7 компанийн 10 бонд, 2 хөрөнгө оруулалтын сан, 6 хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас бүртгэлтэй байна.
3.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй.
3.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	Тайлант хугацаанд зээл аваагүй болно.
4.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 04 сарын 10-ны өдрийн №20 шийдвэрээр Засгийн газрын дотоод үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан гүйцэтгэхтэй холбоотойгоор Сангийн яамтай "Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг гүйцэтгүүлэх тухай гэрээ"-г байгуулах зөвшөөрлийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Долгөөн)-д олгосон байна.		
4.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл	
Хавсралт 1-ийг үзнэ үү.		
5.	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	

ТУЗ-ийн үүрэг

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь МХБ-ийн үйл ажиллагааны үр дүнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн өмнө хариуцлага хүлээдэг.

ТУЗ гүйцэтгэх захирлын ажлын үр дүнг үнэлэх, дүгнэх, томилох, дотоод хяналт, эрсдэлийн удирдлага, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах зэрэг үүрэгтэй. Компанийн дунд хугацаанд хэрэгжүүлэх стратегийг тодорхойлж, түүний хэрэгжилтэд хяналт тавьж, удирдамж, зөвлөмжөөр хангаж ажиллалаа. Тайлант хугацаанд МХБ-ийн гүйцэтгэх удирдлагын баг үйл ажиллагааны стратеги, зорилго, зорилтоо хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавих зорилгоор тогтмол хуралдсан байна. ТУЗ-ийн үүргийг “Монголын хөрөнгийн бирж ХК-ийн дүрэм” болон “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-д тодорхой заасан байдаг.

ТУЗ-ийн хороод

МХБ нь ТУЗ-өөс даалгасан тодорхой үүрэг хариуцлага бүхий байнгын 4 хороотой ба эдгээр хороод нь ТУЗ-ийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг болох зорилгоор санал дүгнэлт гаргах үндсэн зорилготой. Хороодын үйл ажиллагааг “Компанийн дүрэм” болон “Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам”-аар тус тус зохицуулдаг.

ТУЗ нь дараах байнгын хороодтой:

- Нэр дэвшүүлэх хороо;
- Аудитын хороо;
- Цалин, урамшууллын хороо.
- Эрсдэл (комплаенс)-ын удирдлагын хороо

ТУЗ-ийн гишүүн нь нэгээс дээш хороонд ажиллаж болно. Компанийн тухай хуульд ТУЗ-ийн хараат бус гишүүн нь аудитын хороонд ажиллахаар заасан байдаг.

ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, шинэчлэх

ТУЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүнийг бүрдүүлэхэд хараат бус үнэлгээ дүгнэлт гаргах зорилгоор нэр дэвшүүлэх хороог байгуулдаг. Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүдийн ур чадвар, туршилагыг хянан шалгаж, гишүүдийн ур чадвар МХБ-ийн үйл ажиллагааны стратегийг тодорхойлох, түүний хэрэгжилтэд хяналт тавих зэрэг үйл ажиллагааг хангаж ажиллахад зохистой эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгдөг. Энэхүү үнэлэлт, дүгнэлтэд үндэслэн ТУЗ-ийн бүрэлдэхүүнд шинээр оруулах гишүүнийг нэр дэвшүүлдэг. Гишүүдийг томилохоос өмнө Компанийн тухай хууль болон холбогдох бусад дүрэм журмын дагуу боловсрол, ур чадвар, өмнөх ажил эрхлэлтийн түүх, их хэмжээний зээлийн өртэй эсэх, гэмт хэрэгт холбогдсон эсэх зэрэг асуудлаар цогц судалгаа, шинжилгээг мөн хийдэг.

ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлөх, улируулан сонгох

ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар 3 жилийн хугацаатай сонгодог бөгөөд гишүүнийг улируулан сонгож болно. Чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан ТУЗ-ийн гишүүнийг орлох гишүүнийг нөхөн сонгох хүртэл ТУЗ түр томилж болдог. 2023 онд гишүүн С.Тулга, Ч.Дондогмаа, Д.Баянзул, М.Санжаадорж, Л.Наранчимэг, Р.Гандиймаа, А.Анар нар улиран сонгогдсон бол Д.Энхбаатар, А.Батпүрэв нар өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж, Г.Лхагвадорж, Г.Лхамдулам нарыг нөхөн томилсон. Харин Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар С.Тулга, Ч.Дондогмаа, Д.Баянзул, М.Санжаадорж, Л.Наранчимэг, Р.Гандиймаа, А.Анар, Г.Лхагвадорж, Г.Лхамдулам нарыг чөлөөлж, Д.Тогтохбаяр, Ж.Цогтбаяр, Ж.Бямбасүрэн, Т.Ганбаатар, С.Баянцогт, Р.Мөнхтөр, Н.Улаанхүү, Н.Отгончимэг, М.Банзрагч нарыг шинээр томилсон байна.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

ТУЗ үйл ажиллагаагаа хэвийн явуулах, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах зорилгоор ТУЗ-д шууд хариуцлага хүлээх нарийн бичгийн даргыг томилох үүрэгтэй. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байх шаардлагатай бөгөөд ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилдог.

2023 онд уг албан тушаалыг эрхэлж байгаа этгээдэд өөрчлөлт орж, 2023 оны 05 дугаар сард шинээр томилсон ба холбогдох гэрчилгээг авсан байна..

6.	Үнэт цаас гаргагчийн засаглалтай холбоотой тайлан мэдээлэл
----	--

ТУЗ нь 2025 оны эхний хагас жилд нийт 12 удаа хуралдаж Компанийн 2024 оны цэвэр ашигаас ногдол ашиг хуваарилах, Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах, Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа, Үнэт цаасны арилжаатай холбоотой журам батлах, Уул уурхай, Үнэт цаасны арилжааны брокерт

гишүүнчлэл олгох, Хадгаламжийн сертификатыг бүртгэх журам батлах, Дахин үнэлэх, актлах хөрөнгийн талаар дүгнэлт гаргах зэрэг нийт 41 асуудлыг хэлэлцэж, 41 шийдвэр гаргасан. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо 5 удаа хуралдаж, 14 асуудлыг хэлэлцсэн, нэр дэвшүүлэх хороо нь 3 удаа хуралдаж, 3 асуудлыг хэлэлцсэн, цалин урамшууллын хороо нь 4 удаа хуралдаж, 4 асуудлыг хэлэлцсэн байна.

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Б.ДӨЛГӨӨН

Албан тушаал: "Монголын Хөрөнгийн Бирж" ХК-ийн гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гарын үсэг:

Мэдээлэл бэлтгэж, хургуулсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Х.ЭРДЭНЭБҮРЭН

Албан тушаал: "Монголын Хөрөнгийн Бирж" ХК-ийн захиргаа, санхүүгийн газрын захирал

Гарын үсэг:



“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан

/2025 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар/

"Монголын хөрөнгийн бирж" ХК нь Улсын Их Хурал, Засгийн газрын холбогдох шийдвэрийн дагуу 2022 оны 12 дугаар сард нэмэлт хувьцаагаа олон нийтэд санал болгон нээлттэй арилжин нийт 11.9 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн билээ.

Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын талаар үнэт цаасны танилцуулгад тодорхой тусгасан бөгөөд компанийн дунд хугацааны бизнес төлөвлөгөөний дагуу татан төвлөрүүлсэн хөрөнгийг дараах байдлаар зарцуулахаар төлөвлөсөн болно.

Хүснэгт №1. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө

№	Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын төлөвлөгөө	
1	Арилжааны систем сайжруулалт	63.7%
2	Мэдээлэл технологийн аюулгүй байдал	10.7%
3	Дотоод үйл ажиллагааны цахимжуулалт	6.1%
4	Хөрөнгийн зах зээлийн сургалт үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгох	19.5%
Нийт		100.0%

Компани 2025 онд нийт татан төвлөрүүлсэн хөрөнгөөс 3,660.7 сая төгрөгийн зарцуулалт хийхээр төлөвлөн компанийн ТУЗ-ийн 2024 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Үүнд:

- Арилжааны дэд бүтэц болох ИТ системийн арилжаа, хяналтын программ хангамж болон техник хангамжийн шинэчлэл, хаалттай хувьцаат компанийн хувьцааг бүртгэх, арилжих системийн нэвтрүүлэлт, design study хийх ажлуудад нийт 3,154.9 сая төгрөг;
- Мэдээлэл технологийн аюулгүй байдлыг хангахад шаардлагатай сүлжээний болон тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, бусад шаардлагатай лицензүүдийн (Fortinet, Endpoint, Data Loss Prevention, Privileged Access Management) худалдан авалтад нийт 164.8 сая төгрөг;
- Дотоод үйл ажиллагааг цахимжуулах зорилгоор дундын мэдээллийн сангийн систем нэвтрүүлэх ажилд 200.0 сая төгрөг;
- Хөрөнгийн зах зээлийн сургалт, үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгоход 140.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг тус тус хийхээр төлөвлөсөн болно.



Тайлант хугацаанд Мэдээлэл технологийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Fortinet болон Endpoint лиценз худалдан авахад 43.4 сая төгрөг, Хөрөнгийн зах зээлийн сургалт үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгох зорилгоор батлагдсан зураг, төсвийн дагуу дэлгэц худалдан авах, барилгын гадна фасадын засвар болон дээврийн борооны ус хаялгын ажилд нийт 137.5 сая төгрөг, нийт 180.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн дагуу зохион байгуулж, хэрэгжүүлэн ажилласан байна. Арилжааны систем сайжруулалт, дотоод үйл ажиллагааны цахимжуулалтын зорилгоор хийгдэх ажлуудын судалгаа, бэлтгэл ажлын үе шатанд явж байгаа ба 3 дугаар улиралд багтаан холбогдох тендерүүдийг зарлахаар төлөвлөн ажиллаж байна.

Хүснэгт №2. Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан 2025.06.30 /мян.төг/

№	Бараа, ажил үйлчилгээний нэрс	Төлөвлөгөө		2025 он		
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл 2025.06.30	
		Дүн	Хувь	Дүн	Дүн	Хувь
1	Арилжааны системийн сайжруулалт	7,590,339	64%	3,154,986	-	-
2	Мэдээлэл технологийн аюулгүй байдал	1,274,986	11%	164,840	43,395	3%
3	Дотоод үйл ажиллагааны цахимжуулалт	726,861	6%	200,000	-	-
4	Хөрөнгийн зах зээлийн сургалт үйлчилгээ, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх төв бий болгох зорилгоор барилга байгууламжийн дотоод зохион байгуулалтын өөрчлөлтөд оруулах хөрөнгө оруулалт	2,323,573	20%	140,971	137,490	6%
Нийт		11,915,760	100%	3,660,797	180,885	2%

Татан төвлөрүүлсэн хөрөнгийн төлөвлөгөөнд тусгагдсан бараа, ажил, үйлчилгээг худалдаж авах ажиллагаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хууль болон компанийн үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зориулалтын дагуу үе шаттайгаар хэрэгжиж байгаа болно.

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК